

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

2011-03-02

Чойр хот

Шалгуур үзүүлэлт	Биелэлт
Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (Байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод болсон байна)	
<p>1.1. Дараахь зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <p>-байгууллагын эрхэм зорилго үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ түүний үр дүн</p> <p>-албан хаагчийн ёс зүйн дүрэм</p> <p>-Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь</p> <p>-Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт</p> <p>-Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар</p>	<p>Дараахь зүйлсийг байгууллагын мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байна.</p> <p>- Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлээ байнгын байдлаар, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг тухай бүр нь өөрчилж тавьж байна;</p> <p>- Байгууллага бүр албан хаагчийн ёс зүйн дүрмээ / салбар бүр өөр, өөрийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж байна / ил тавьсан. Шинээр гарсан Ёс зүйн дүрмээр Ерөнхий менежерүүд, төрийн захиргааны албан хаагчдад сургалт явуулсан. Төрийн албан хаагчдын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж, төрийн албаны үйлчилгээний стандарт зэргийг ил тавьсан</p> <p>- Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, төрийн албан хаагч бүрийн хариуцсан ажил, харилцах утас, имайл хаяг зэргийг тодорхой бичиж зургийн хамт тавьсан.</p> <p>- Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалтыг гарын авлагаар бэлдэж өгөхөөс гадна, нэг цэгийн үйлчилгээний ширээ бүрийн дээр хавчуурга самбар хийж товч, ойлгомжтой хэлбэрээр тавьж байна;</p> <p>- Хэлтсүүд үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар зэргийг мэдээллийг самбарт байрлуулан шинэчилж хэвшсэн. Өргөдөл гомдол, эрх зүйн туслалцаа төвийн үйл ажиллагаа, жижиг дунд үйлдвэрийн зээл олгох журам , төсөл хүлээн авах гэх мэт иргэдэд шууд үйлчилгээ үзүүлдэг үйл ажиллагааны дүрэм журмуудыг хамгийн ойлгомжтой хэлбэрээр тавьж, гарын авлага материал бэлтгэж сум, баг, иргэдэд өгч байна.</p> <p style="text-align: right;"><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>

<p>1.2. Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Засгийн газрын 2007 оны 264 дүгээр тогтоолын дагуу “Нэг цонхны үйлчилгээ”-г 2009 оны 2-р сарын 16-ний өдрөөс эхлэн нээн ажиллуулж байна.</p> <p>“Нэг цонхны үйлчилгээ”-г нээн ажиллуулснаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээ, Нийгмийн даатгалын үйлчилгээ, Худалдаа үйлчилгээ, Газрын харилцааны үйлчилгээ, Улсын бүртгэлийн үйлчилгээ, Мэдээлэл лавлагаа, Нотариатын үйлчилгээ, Хаан банк гэсэн 9 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Дээрх байгууллагууд өөрсдийн үзүүлдэг үйлчилгээгээ, ажлын чиг үүргийг иргэдэд харагдахуйц газар байрлуулан хэвийн үйл ажиллагаагаа явуулж хэвшээд байна. “Нэг цонхны үйлчилгээ” нээгдсэнээр иргэд төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой болж, орж ирсэн иргэдийн сэтгэгдэл өндөр байна. Нэг цонхны үйлчилгээний талаар 5 асуултаар 60 гаруй иргэнээс санал асуулга авч нэгтгэн үйл ажиллагаандаа дүгнэлт хийн ажиллаж байна. Энэ хугацаанд “Нэг цонхны үйлчилгээ”-ээр 42089 иргэн үйлчлүүлсэн байна.</p> <p>Иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөгийг нийт 7 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс албад болон иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд давхардсан тоогоор 14140 иргэнд үйлчилгээ үзүүлж, 10098 гарын авлага, тараах материал, ном, сонин тарааж, 377 иргэнээс санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч, 373 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэлээ.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>1.3. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Мэдээллийн нээлттэй байдлыг хангах хүрээнд аливаа мэдээллийг нууцлах, төлбөр авдаг явдал байхгүй. Иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөгөөр иргэдийг мэдээ мэдээллээр хангахыг зорьдог. Иргэд мэдээлэл, зөвлөгөө авахтай холбоотой аливаа гомдол маргаан гаргаагүй.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>1.4. Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх</p>	<p>Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн яамаар тогтмол хянуулж хэвшсэн. Манайд улсын бүртгэлийн дугаар бүхий 2 нийтээр дагаж мөрдөх шийдвэр мөрдөж байна. Гаргасан захирамжуудыг нээлттэй мэдээлж, нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах талаар сургалт зохион байгуулж байна. Нийт бодлого шийдвэр боловсруулах, гаргах эрх үүрэг бүхий 200 гаруй төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>

<p>1.5. Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх</p>	<p>Аймгийн Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт : “ ... 1.1.1-д төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэн, авилга, хээл хахуультай тууштай тэмцэж, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.</p> <p>1.1.3. Төр, иргэний нийгэм /ТББ/, аж ахуйн нэгж, байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, түншлэлийн харилцааг өргөжүүлэн, төрийн зарим чиг үүргийн ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэн үр дүнг тооцно.</p> <p>1.1.4. Багийн ажиллах нөхцөлийг сайжруулж, төрийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, сум бүрийг жишиг багтай болгоно.</p> <p>1.2.1. Хөтөлбөр бодлого боловсруулах, нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах явцыг нээлттэй болгож, аль болох ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тал болон иргэдийн санаа бодолд тулгуурлан шийдвэрлэж хэвшинэ. гэх мэт олон заалтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн төлөө бодлого боловсруулах зорилгоор хүүхдийн аж байдлын судалгааг гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> - Хүн ам зүйн мэдээлэл - Хүүхдийн эрүүл мэнд - Хүүхдийн халамж хамгаалал - Хүүхдийн гэмт хэрэг - Орон нутгийн иргэний бүртгэлийн талаарх мэдээлэл - Сургуулийн өмнөх боловсрол - ЕБС-д суралцагчид гэх мэт судалгааг ажилдаа ашиглаж байна. <p>Хурлаас гаргасан тогтоол шийдвэрийн ил тод тавьж сурталчилдаг.</p> <p>Төрийн албан хаагчдаас орон нутагт доголдож буй асуудлууд, шинэлэг санаачлан хийж гүйцэтгэх ажлуудын талаар санал асуулга авч дүгнэсэн. Санал асуулгаар ногоон байгууламжтай болох санал ихэнх хувийг эзэлсний дагуу мод тариалах бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд Архи согтууруулах ундаагаар үйлчлэх, тусгай зөвшөөрөл олгох журмыг шинэчлэхэд сонирхогч нийгмийн бүлгүүдэд танилцуулж санал авсан. Мөн дэд хөтөлбөрүүдийг боловсруулахад холбогдох сумд, холбогдогч талуудад танилцуулан санал авч хэвшсэн байна.</p> <p style="text-align: center;"><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>1.6. Санал, хүсэлт, өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг дэвтэр ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бүр иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй утас, санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр, Иргэдийг хүлээн авах өрөө, хуваарийн дагуу айл өрхөөр орох зэргээс гадна, "Нэг цонхны үйлчилгээ", "Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг", FM радиогоор үйл ажиллагаагаа танилцуулах иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд нь шийдвэрлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Санал асуулга, тавьсан хүсэлтийн мөрөөр зохион байгуулсан арга хэмжээг дараагийн өдөрлөг дээр нь танилцуулж хэвшив.</p> <p>Сумд, багийн өдөрлөгийг тогтмолжуулж өдөрлөгт төрийн байгууллагууд ээлжээр ажлаа танилцуулж өдөрлөг дээр тавигдсан санал хүсэлтийн барагдуулалтыг дараагийн өдөрлөг дээр тайлагнаж хэвшсэн. Хөдөөгийн багуудын Засаг дарга нарыг унаатай болгож 20-30 хоногт айл өрхөөрөө орж байхаар төлөвлөж үр дүнг нь тооцож байна.</p>

	<p>Он гарсаар Таксын үйлчилгээ, бизнес эрхлэгчид, залуучууд, ахмадын төлөөлөл, ТББ-ынхан гэх мэт иргэдийг сонирхолын бүлгээр аймгийн удирдлагууд хүлээн авч уулзаж бодлого чиглэлээ таниулж тэдний тавьсан хүсэлтийг шийдвэрлэж өгсөн.</p> <p>2009 оны үйл ажиллагааны үр дүн, 2010 оны бодлого чиглэлээ иргэдэдээ таниулах уулзалтыг сумдад зохион байгуулж нийт 484 иргэн оролцож, тэдний санал сэтгэгдэлийг сонсох ажлыг зохион байгууллаа.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Иргэдээ сонсох өдөр” аян зохион байгуулж, аяны хүрээнд Сүмбэр, Шивээговь сумын 1060 айлаар 3560-иад иргэнтэй уулзаж бодлого шийдвэр, ажлаа танилцуулж 768 иргэнээс аймаг, сум, баг болон бусад төрийн үйлчилгээний байгуулагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ чанар хүртээмжээр санал асуулга авч дүгнэлт хийж ажиллалаа.</p> <p>Энэ үеэр иргэдээс 128 санал хүсэлт гарсныг холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлж хэрхэн шийдвэрлэсэн талаархи тайланг авч байна.</p> <p>Аймгийн Засаг дарга нэн түрүүн тусламж дэмжлэг шаардлагатай байгаа 73 өрхөд нэг ээлжийн шинэ хувцас, хүнсний тусалцаа үзүүлж гэр оронгүй гэсэн 14 өрхөд дахин судалгаа хийж 3 өрхөд гэр олголоо .</p> <p>Аймгийн Засаг дарга нөөцөөсөө хөрөнгө гаргаж өвөл, хаврын цагийн байдлыг тогтоох, малчдын амьдрал ахуйтай танилцах ажлаар аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нар аймгийн Засаг даргын зөвлөлийн зарим гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд 2 удаа явж давхардсан тоогоор 258 өрхөөр орж хүн, мал эмнэлгийн болон төрийн бусад үйлчилгээ үзүүлж, өвөлжилтийн байдал, амьдрал ахуйтай нь танилцав Энэ ажилд 10 машин 45 хүн, 7000 гаруй км замыг туулж 1200 литр бензин зарцуулсан байна.</p> <p style="text-align: right;"><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>1.7. Өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх</p>	<p>Өргөдөл гомдлын мэдээг нутгийн захиргааны байгууллага, агентлагуудаас авч, СӨХ-ийн шийдвэрлэлт, иргэдийн санал хүсэлтийн мөрөөр авч байгаа арга хэмжээг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж, анхаарч ажиллаж байгаа.</p> <p><i>Тайлант онд</i> Аймгийн хэмжээнд 5295 санал, өргөдөл, гомдол хүлээн авсан байна.</p> <p>Ирсэн өргөдөл гомдлын 5255 буюу 99.2 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 40 буюу 0.8 хувийг шийдвэрлэх хугацаа болоогүй байна.</p> <p>Хүлээн авсан өргөдөл, гомдлоос 228-г амаар, 4039-г бичгээр, 1028-г цахим сүлжээ, утсаар хүлээн авсан байна.</p> <p>Дээд газраас, аймгийн Засаг даргаас шилжүүлсэн 38 өргөдөл байгаагийн 30 нь хугацаанд нь шийдвэрлэгдэж, хугацаа болоогүй 8 өргөдөл, хүсэлт байна.</p> <p>Иргэдийн санал хүсэлтийг байгууллагууд бичгээр, утсаар, веб хаягаар, санал хүсэлтийн хайрцаг, иргэдийг хүлээн авах өрөө, “Иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөг”, “Нэг цонхны үйлчилгээ”, Иргэдтэй уулзах уулзалт, айл өрхөөр орж ахуй амьдралтай танилцах, FM радиогоор авч, хугацаанд нь шийдвэрлэж хэвшээд байна.</p> <p style="text-align: right;"><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал (Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, түүний хэрэгжилтийн явц, үр дүн нээлттэй ил тод болсон байна)</p>	
<p>2.1.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх</p>	<p>Удирдлагын академийн мэргэшсэн багштай хамтран стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлж байна. Жил бүрийн байгууллагын төлөвлөгөөнд хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэх асуудлыг тодорхой тусган, тухайн жилд чухал ач холбогдолтой гэж үзсэн ажлуудыг тусгай захиалгат</p>

	<p>бүтээгдэхүүнд оруулж хэрэгжилтийг журмын дагуу үнэлж дүгнэж байна.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>2.2. Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил, тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг стратеги төлөвлөгөөнд тодорхой тусгасан. Байгууллага бүр албан хаагчдын товч мэдээлэл, гүйцэтгэх чиг үүргийг ойлгомжтой хэлбэрээр өрөө бүрийн үүдэнд ил тавьсан</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>2.3. Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх</p>	<p>Хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэхэд албан хаагчид оролцох боломж бүрэн нээлттэй. Аливаа журам, хөтөлбөр төлөвлөгөө, сургалтанд санал авч хэрэгжүүлдэг. Аймгийн Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “ ... 1.1.1-д төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэн, авилга, хээл хахуультай тууштай тэмцэж, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна. гэж заасныг хэрэгжүүлж сумдын Засаг дарга нартай байгуулсан батламжид авлига, хүнд суртлын талаар, агентлаг хэлтсийн дарга нар, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд ёс зүй, хариуцлага тооцох зохицуулалтуудыг оруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>2.4. Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх</p>	<p>Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг, нэг цонхны үйлчилгээний газраар, үйлчлүүлж байгаа иргэд, айл өрхөөр орж иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, ил тод тавьж түүний мөрөөр ажил зохион байгуулж эргэж мэдээлж хэвшлээ. Байгууллагын соёл, үйл ажиллагааны нээлттэй байдал, албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, харилцан мэдээлэл солилцох, кабинетийн сургалтыг жилд 15 удаа зохион байгуулдаг.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>2.5. Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх</p>	<p>Төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалтыг болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг ил тод шударга явуулахад онцгой анхаарч ажилладаг удирдах ажилтныг сонгон шалгаруулалтын зарыг орон нутгийн болон төвийн хэвлэлүүдэд тавьж мэдээлэхээс гадна байгууллага, худалдаа үйлчилгээний газар зэрэг мэдээлэл авч болох бүх сувгаар нээлттэй тавьдаг. Ажлын 10-11 байрыг 2 удаа зарлаж шалгалт авахад 9 ажлын байранд 51 иргэнийг бүртгэж 39 иргэн 9 ажлын байранд тэнцэж нөөцөд бүртгүүлэхээр ТА3-д хүргүүлээд байна.</p> <p>Мөн хугацаанд Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 7 ажлын байр, төсвийн байгууллагын Ерөнхий менежерийн 3 ажлын байранд сонгон шалгаруулалт явуулж томилох эрх бүхий этгээдэд хамгийн өндөр оноо авсныг нь санал болгож журмын дагуу томилуулав.</p> <p>Манай аймагт мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалттай холбоотой маргаан, зөрчил гараагүй. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орсноос хойш, мэргэшлийн шалгалтад орж нөөцөд бүртгэгдээгүй иргэн төрийн захиргааны албанд түр томилогдон ажиллах явдал байхгүй болсон.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>2.6. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх</p>	<p>Төрийн албаны зөвлөлөөс баталсан “Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ дүгнэх журам”-ын дагуу дүгнэдэг. Албан хаагчдын үр дүнгийн гэрээний шалгуур үзүүлэлтийг нарийвчлан гаргаж, дүгнэхдээ үзүүлэлт бүрийг нарийн тооцож байна. Ерөнхий менежерүүдийн ажилд ХШҮ хийдэг журам гаргаад мөрдөж байна. ХШҮ-ний үр дүнгээр Ерөнхий менежер 5, төрийн албан хаагч 6 хүнийг аймгийн Засаг дарга шагнаж урамшуулав</p> <p>Нэг цэгийг үйлчилгээний албан хаагчдын үйлчилгээг иргэдээр үнэлүүлдэг журам</p>

гаргаж үнэлүүлж байна. **Хэрэгжилт 100,0 хувь**

Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал (Байгууллагын төсөв боловсруулах, гүйцэтгэх, тайлагнах үйл явц нээлттэй, ил тод болсон байна)

<p>3.1. Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх</p>	<p>Төсвийн төслийг аймгийн нийгэм эдийн засгийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон байгууллагуудын үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нь уялдуулан боловсруулж төрийн бус байгууллага, иргэдийн саналыг авч хэлэлцүүлэн 2010 оны 12 сарын 23-ны өдөр аймгийн ИТХ-ын 10 дугаар хуралдаанаар аймгийн төсвийн орлогыг 1998,3 сая төгрөг, төсвийн урсгал зарлагыг 1682,9 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтыг 514,0 сая төгрөгөөр ,улсын төсвөөс авах татаас 198,6 сая төгрөгөөр батлуулсан.</p> <p><u>Хэрэгжилт 100 хувь</u></p>
<p>3.2. Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн байх</p>	<p>2010 оны орон нутгийн төсөв болон хөрөнгө оруулалтын ажлуудыг Говьсүмбэрийн мэдээ сонинны 002/019 дугаарт тавьж, аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбарт 1-12 сарын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг тогтмол гаргаж, сумдын нээлттэй хаалганы өдөрөөр иргэдэд гарын авлага болгон 300 ширхэг боршур тараасан. Төсвийн байгууллагууд төсвийн ил тод байдлын самбартай болж, төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлүүдийг сар бүр самбарт тавьж нэг удаагийн тэтгэмжийн, бичиг хэргийн , урсгал засвар, төлбөр хураамжийн зардлуудын гүйцэтгэлийг нэр төрлөөр гаргаж байгууллагын ажилчиддаа танилцуулж олон нийтэд мэдээллийг чөлөөтэй үзэж болох нөхцөлийг хангаж байгууллагынхаа төсвийн ил тодын самбарт тавьдаг болсон.</p> <p><u>Хэрэгжилт 100 хувь</u></p>
<p>3.3. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтанд хяналт тавьх боломжийг хангасан байх</p>	<p>Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас жилийн санхүүгийн тайланг байгууллагын мэдээллийн самбарт байрлуулан иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтанд хяналт тавих боломжийг ханган ажиллаж байна.</p> <p><u>Хэрэгжилт 100 хувь</u></p>
<p>3.4. Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх</p>	<p>Төсвийн байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, Говьсүмбэрийн мэдээ сонинд болон байгууллагын мэдээллийн самбарт мэдээлэл нийтэлсэн.</p> <p><u>Хэрэгжилт 100 хувь</u></p>
<p>3.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлөөр хангасан байна</p>	<p>2010 оны Орон нутгийн төсөвт 4 удаа 1185,1 сая төгрөгийн тодотгол хийж Орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэр төрлөөр, төсвийн урсгал зардлыг байгууллага нэг бүрээр нь Говьсүмбэрийн мэдээ сонин, аймгийн веб сайтад байршуулан Санхүү төрийн сангийн хэлтсийн мэдээллийн самбарт тавьж иргэд, байгууллагуудыг төсвийн талаар мэдээлэл авах нөхцлийг хангаж ажиллалаа.</p> <p><u>Хэрэгжилт 100 хувь</u></p>
<p>3.6. Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх</p>	<p>Улсын бүртгэлийн хэлтэс 22 нэр төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж МУ-ын ЗГ-ын 2003 оны 213-р тогтоолоор баталсан Эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ, Сангийн сайд, Гадаад хэргийн сайдын 2006 оны 455/72/205 дугаар хамтарсан тушаалаар баталсан гадаад паспортын төлбөр, хураамж, Хууль зүйн дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар /2007 оны 8 сарын 23-ний өдрийн 171/228-р иргэний үнэмлэхний үнэ /эдгээр тушаал, тогтоолоор батлагдсан үнэ тарифийн дагуу үйлчилгээний хөлс, хураамж авч 2010 онд орон</p>

	<p>нутгийн төсөвт 29,4 сая төгрөг, улсын төсөвт 46,5 сая төгрөгийн төлбөр хураамжийн орлого оруулсан. ГХБХБГазар 4 төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж Газрын төлбөрийн тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн дагуу төлбөр хураамж авч орон нутгийн орлогод 35,2 сая төгрөгийг оруулсан байна. төлбөр хураамжийн хэмжээ үйлчилгээний хөлсний үнэ тарифаар боршур хийж иргэдэд тараах мөн самбарт тавих, аймгийн веб сайтад байршуулах зэрэг хэлбэрээр олон нийтэд мэдээлэл хүргэж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100 хувь</p>
<p>3.7. Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Улсын бүртгэлийн хэлтэс 20, ГХБХБГазар 4 төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлдэг, мөн нэгдсэн эмнэлэг, УС-ДУ ОНӨҮГ, Цахилгаан шугам сүлжээ зэрэг төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд мөрдөж байгаа дүрэм журам, үйлчилгээнийхээ тарифыг ил тод байрлуулж жижиг боршур болгон үйлчлүүлэгч, хэрэглэгчиддээ өгсөн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100 хувь</p>
<p>Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал (Байгууллагын худалдан авах ажиллагаа нээлттэй, ил тод болсон байна)</p>	
<p>4.1. Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх</p>	<p>Сангийн сайдын 2009 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 9-11/1101 тоот, Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2009 оны хөрөнгө оруулалтын бодлогыг орон нутгийн үйлдвэрлэгчдэд давуу эрх олгон, тэдний үйл ажиллагааг дэмжихэд чиглүүллээ. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын тухайн оны төлөвлөгөөг батлуулсны дараа ТБОНӨХБАҮХА-тухай 45 дугаар зүйлийн дагуу захиалагчдыг сонгон, тухайн байгууллагуудад хийгдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хуульд заасны журмын дагуу зохион байгуулах албан тоотыг батлагдсан төлөвлөгөөний хамт хүргүүлж, хяналтыг тавьж ажиллаж байна. 2009 онд хийгдэх худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг “Говьсүмбэрийн мэдээ” сонинд 2 удаа, сумдын нээлттэй хаалганы өдрөөр 5 удаа тарааж өгөх материал болон иргэдэд тарааж өгөн сурталчилгаа хийсэн. Мөн 2009 оны бүтээн байгуулалтаар 2 м х 1,5 м хэмжээтэй хулдаасан хэвлэл дээр самбар хийж, АЗТГ-т байрлуулсан. Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тайлагнах, санхүүжилт олгохдоо 2008 оны Сангийн сайдын баталсан журмыг мөрдөж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 90,0 хувь</p>
<p>4.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчилж байх</p>	<p>2010 онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нээлттэй тендерийн журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах 4 ажлын тендерийн урилгыг Сангийн яамны худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn сайтад байрлуулж, үр дүнг нийтлэхээс гадна “Зууны мэдээ”, “Говьсүмбэрийн мэдээ” сонинд нийтлүүлсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100,0 хувь</p>
<p>4.3. Үйлчилгээний хооронд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх</p>	<p>Захиалагч байгууллагууд өөрсдөө үнэлгээний хороо байгуулж ажиллаж байна. Хуулийн 47.5.заасны дагуу худалдан авах ажиллагааны болон тухайн ажлын чиглэлээр мэргэшсэн, сургалтанд суусан үнэмлэхтэй, энэ хуулийн 50.1-д заасан төрийн албан хаагчийн үүргийг сүүлийн 1 жилийн хугацаанд зөрчөөгүй албан хаагчдын үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг хүн бүрээр бичүүлэн авч ажиллуулж байна. 2010 онд ИНБ, Хувийн хэвшлийнхэн, Аймгийн Засаг даргатай хамтран гурвалсан</p>

	<p>гэрээ байгуулан ажилласны үр дүнд худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд хяналтын үүрэгтэйгээр ТББ, иргэний нийгмийн 14 төлөөллийг оролцуулсан.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>4.4. Тендерт оролцохыг сонирхогчидод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байна.</p>	<p>Тендер оролцогчидод тендерийн урилга, техникийн тодорхойлолт, үнийн санал явуулдаг. Тусгай зөвшөөрөл, санхүүгийн чадавхи болон тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл шаардлагыг хангасан, хамгийн бага үнэ санал болгосон оролцогчийг хууль тогтоомжийн дагуу шалгаруулж гэрээ байгуулан ажилладаг. 2010 онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4 ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг Сангийн яамны худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn сайтад байрлуулсан.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>4.5. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх</p>	<p>Худалдан авах ажиллагаанд тендерт шалгарсан оролцогчид гэрээ хийх санал, шалгараагүй оролцогчид шалгарч чадаагүй шалтгааныг хуулийн үндэслэл тайлбартай бичин албан тоотоор хүргүүлж хэвшсэн бөгөөд шалгарсан оролцогчийн талаарх мэдээллийг Сангийн яамны худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn сайтад тухай бүр нь нийтэлж хэвшээд байна.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>4.6. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх</p>	<p>МУ-ын Сайдын 2008 оны 2-р сарын 12-ны өдрийн 58 дугаар тушаалаар батлагдсан “Улсын болон орон нутгийн төсөв, МУ-г хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, их засвар, худалдан авах тоног төхөөрөмж”-ийн мэдээг сар бүрийн 3-ны дотор гэрээ байгуулан Төсвийн ерөнхийлэн захирагчид болон Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлдэг.</p> <p>2010 оны улсын болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайланг www.gobisumber.gov.mn сайт болон “Говьсүмбэрийн мэдээ” сонинд тус бүр 1 удаа нийтлүүлсэн.</p> <p>Мөн онд улсын болон орон нутгийн төсөв, МУ-г хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн мэдээг сар бүрийн 3-ны дотор гэрээ байгуулсан Төсвийн ерөнхийлэн захирагчид болон Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж ажилласан.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>4.7. Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх</p>	<p>Баянтал суманд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах халуун усны барилгын ажлын гүйцэтгэчийг шалгаруулах тендерт оролцон “Оюу суврага” ХХК шалгарсан боловч тусгай зөвшөөрөл нь хуурамч байсан тул тендерийг хүчингүй болгон энэ талаар Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газарт мэдэгдсэн.</p> <p>2010 онд бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой зөрчил гараагүй болно.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>4.8. Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчийг мэргэшүүлсэн байх</p>	<p>Худалдан авах ажиллагааны чиглэлээр 2006, 2007, 2008-онуудад 3 удаа сургалт явуулж нийт 46 албан хаагчдыг мэргэшүүлсэн.</p> <p>2010 онд Мерси кор ОУБ-тай хамтран Сангийн яамны худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг орон нутагт зохион байгуулж холбогдох төрийн болон Төрийн бус байгууллагын 23 хүнийг хамруулж, сертификаттай болгосон.</p> <p><u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>

<p>4.9. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байна.</p>	<p>2009, 2010 оны хагас жилийн худалдан авах ажиллагаанд хийсэн Аудитын шалгалтын дүнг “Говьсүмбэрийн мэдээ” сонин болон, байгууллагын мэдээллийн самбарт байрлуулж олон нийтэд танилцах боломжийг бүрдүүлж өгсөн. <u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>
<p>4.10. Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх</p>	<p>2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Шивээговь сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил”-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулалтад оролцсон “МД констракшн” ХХК гомдол гаргасныг Сангийн яаманд хянуулж, шийдвэр захиалагчийн талд гарсныг “Говьсүмбэрийн мэдээ” сонин болон байгууллагын мэдээллийн самбраар мэдээлсэн. <u>Хэрэгжилт 100,0 хувь</u></p>

АЙМГИЙН ЗАСАГ ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА

Д.УРТНАСАН